



СОЁМБО МЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№75 /519/

2023.05.09

Цаг үе, үйл явдал

ЗХЖШ-ЫН ОРЛОГЧ ДАРГА ХУРАНДАА Т.ГАЛБАДРАХ ТУРШИЛТ, СУДАЛГААНЫ ТӨВД АЖИЛЛАЛАА



Зэвсэгт хүчний судалгааны төвүүдэд Жанжин штабын орлогч дарга, Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн дарга, хурандаа Т.Галбадрах салбар зөвлөлийн гишүүдийн хамт Зэвсэгт хүчний туршилт, судалгааны төвүүдэд ажиллалаа. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050"-д батлан хамгаалах тогтолцоог төгөлдөржүүлж, технологийн

дэвшлийг нэвтрүүлэн батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд 2020 оноос эхлэн Зэвсэгт хүчний ангиудыг түшиглэн туршилт, судалгааны төвүүдийг байгуулж үйл ажиллагааг нь эхлүүлсэн.

Энэ хүрээнд ЗХЖШ-ын Шинжлэн ухаан, технологийн салбар зөвлөлийн гишүүд Зэвсэгт хүчний 011, 013, 065, 189, 337 дугаар ангийг түшиглэн байгуулсан туршилт, судалгааны төвүүдийн сүүлийн жилүүдэд хэрэгжүүлсэн төслийн ажлууд, хойшид хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн туршилт, судалгааны ажлын чиглэлүүдтэй танилцсан юм.

Төвүүдийн үйл ажиллагаатай танилцах ажлын явцад салбар зөвлөлийн гишүүд, төвүүдийн судлаач, алба хаагчидтай судалгаа, шинжилгээний ажлыг үр дүнтэй зохион байгуулж явуулахад тулгамдаж буй асуудлууд, цаашид туршилт, судалгааны төвүүдийн хамтын ажиллагааг

хангах, цэргийн шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээр залуу судлаачдыг гадаадын болон дотоодын их дээд сургуульд сургаж, бэлтгэх талаар санал солилцсоны зэрэгцээ эдгээр төвүүдэд шаардлагатай туршилт, судалгаа, лабораторийн тоног төхөөрөмжөөр хангах, Зэвсэгт хүчний төсөвт шинжлэх ухаан, техник, технологи, туршилт, үйлдвэрлэлийн зардлыг нь нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахаа илэрхийллээ.

Энэ үеэр шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн гишүүн, Кибер аюулгүй байдлын цэргийн командлалын Ерөнхий инженер хурандаа Д.Отгонболд хувийн зүгээс 3D принтерийг Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн "Радиоэлектроникийн туршилт, судалгааны төв"-д гардуулан өглөө.

Дэд хурандаа С.БЯМБА-ОЧИР

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
19	6

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	28

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,465	3,470
EUR	3,830	3,848
CNY	503	504.50
RUB	43.20	43.70
JPY	25.70	25.93
KRW	2.64	2.66

ЗУРХАЙ



2023.05.09 /МЯГМАР ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 19

**ХАВРЫН АДАГ УЛААН ЛУУ
САР
ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ
УЛААГЧИН ТУУЛАЙ ӨДӨР**

Үс засуулбал:

Сайн нөхөртэй нөхөрлөнө
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.23-20.15

Барилдлага:

Үхэх
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
МУНХРАХУЙ

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Эл өдөр сүм, суварга барих, хүүрийн газар эргэх, чуулан үймэхэд сайн. Нүд татваас эцэг эхэд аюул болох, баруун чих хангинавал эхнэртэй учрах, зүүн нь бол идээ ундаа олодох, нохой уливал гэнэт зочид ирэх болой. Энэ өдөр өндөр язгуурт хүний хэл ам болох, тагнай загатнавал их хүн ирэх, бие татвал хэрүүл тэмцэл болох, хөл татвал сайн.

АХМАД Б.БАТБАЯРЫН САНААЧИЛСАН СУДАЛГААНЫ ТӨСӨЛ ШУА-ИЙН ГРАНТ ТӨСӨЛ БОЛЗОЛ ХАНГАЛАА



Монгол Улсын Шинжлэх ухааны академиас жил бүр нийгмийн бодит хэрэглээ болгох боломжтой онолын суурь судалгааны ажлын завсрын болон эцсийн үр дүнд зайлшгүй шаардлагатай нэмэлт судалгаа, тооцоо, үндэслэл, боловсруулалт хийхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний байгууллага, ажилтанд нэг жилийн хугацаатай төслийн "Грант" олгох сонгон шалгаруулалтыг зарладаг уламжлалтай.

Энэ жилийн шалгаруулалтад Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгээс Технологи дамжуулалт, Ре-инженерингийн төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D) ахмад Б.Батбаярын санаачилсан "Буудлагын зэвсгийн сум сумлах багажийн бүтээц" сэдэвт судалгааны төсөл анх удаа шалгарлаа.

"Буудлагын зэвсгийн сум сумлах багажийн бүтээц" судалгааны грант төслийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээг Шинжлэх ухааны академи, Шинжлэх ухаан технологийн сан, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн болон грант төслийн удирдагч нар хамтран байгуулж, баталгаажууллаа.

Доктор (Ph.D) ахмад Б.Батбаяр нь 2019 онд

"Буудлагын зэвсгийн сум үйлдвэрлэх технологийн судалгаа" сэдвээр цэргийн ухааны докторын зэрэг хамгаалсан Батлан хамгаалах салбарын анхны залуу эрдэмтдийн нэг юм.

Тэрээр ҮБХИС-д 2014 онд томилогдон 9 жилийн хугацаанд багшаас ахлах багш, БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан хүртэл дэвшин ажиллаж, 2016 онд ҮБХИС-ийн "Тэргүүний залуу багш"-ийн дэд байр, 2017 онд тэргүүн байр, 2018 онд "Галт хэрэглэл" хөтөч сурах бичиг боловсруулан тэргүүн байр, 2021 онд "Буудлагын зэвсэглэл" хөтөч сурах бичиг боловсруулан дэд байрт шалгарсан амжилт гаргасан байна.

Доктор (Ph.D) ахмад Б.Батбаяр нь нь улс, салбарын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэл 18, нийтлэл, өгүүлэл 16, ном, сурах бичиг, гарын авлага 6, хянан тохиолдуулсан ном бүтээл 4, төсөлт ажил 2, удирдсан дипломын ажил 4, ашигтай загварын патент 4-ийг боловсруулсан зэрэг олон арван эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл туурвижээ.

Референт-эрдэм шинжилгээний ажилтан Э.ТҮВШИН


БАГАНУУР ДҮҮРГИЙН "ДӨЛ-2023" ТЭМЦЭЭНИЙ ШИЛДГҮҮД ТОДОРЛОО



дарга Н.Алтансүх, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга Т.Хашлянуха, "Гүн галуутай", "Боловсрол", "Оюуны эрин" цогцолбор сургуулиудын удирдлага, баг тамирчид болон дүүргийн ард иргэд оролцлоо.



Цэрэг-спортын "Дөл-2023" цогцолбор тэмцээн жагсаал, гардан тулааны үзүүлэх тоглолт, нормативын бэлтгэл, тасгийн гүйлт, тасгийн захирагч нарын тэмцээн гэсэн төрлөөр явагдаж баг тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөхөд шилдэг эмэгтэй тамирчнаар "Боловсрол" цогцолбор сургуулийн 11-1 ангийн сурагч Г.Мөнхжин, Галын бэлтгэлийн аварга тамирчнаар "Боловсрол" цогцолбор сургуулийн 12-2 ангийн



сурагч Б.Золбоо, Гранат шидэлтийн аварга тамирчнаар "Гүн галуутай" цогцолбор сургуулийн 11-4 ангийн сурагч Б.Бадамдорж, Шилдэг тасгийн захирагчаар "Боловсрол" цогцолбор сургуулийн 12-4 ангийн сурагч Л.Энхболд нар тус тус шалгарсан бол нийлбэр дүнгээр "Гүн галуутай" цогцолбор сургуулийн "Шонхор" тасаг тэргүүлж "Боловсрол" цогцолбор сургуулийн "Соёмбо-4" тасаг удаалсан юм.



Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолоор баталсан "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр", Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Монгол цэргийн нэгдсэн холбооноос санаачилсан "Бидний бахархал" төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын "Дөл-2023" цогцолбор тэмцээнийг Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулж явууллаа.

Тус тэмцээний нээлтийн арга хэмжээнд Дүүргийн Засаг дарга С.Даваасүрэн, ЗДТГ-ын цэргийн штабын дарга хурандаа З.Майдар, Боловсролын хэлтсийн

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 687,944,494

Эдгэрсэн

Нийт: 660,363,796

Нас барсан


Нийт: 6,871,731

Цахим шууданд

ҮРЭЭ ЦЭРЭГТ МОРДУУЛАХ МӨЧ ХАМГИЙН БАХАРХАМ ЮМ БИЛЭЭ



2023 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлага улс орон даяар амжилттай явагдаж өндөрлөж байна. Энэ үеэр Орхон аймгаас хүүгээ цэрэгт мордуулж байгаа ээжийн бичлэг цахим сүлжээнд эерэг давлагаа үүсгэж, давхардсан тоогоор нэг сая хүн үзэж, 20 мянган



Ухаарч гүйцээгчн энэ л сэтгэлийг

хүн зүрхээр "булж" эх үрийн нандин холбооны талаар сайхан сэтгэгдлүүд үлдээсэн байв.

Олон мянган ээжид урам зориг өгч, эх орныхоо өмнө эр хүн бүрийн хүлээх үүрэг хариуцлагыг

"ойлгуулсан" ээжийг Орхон аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабынхны тусламжтайгаар өдөржин эрэл сурал болсоор олсон нь Орхон аймгийн Баян-Өндөр сумын харьяат, "Эрдэнэт" ТӨҮГ-ын Дулааны цахилгаан станцын ажилтан Батбаатарын Тунгалагтамир байлаа. Түүнтэй ярилцсанаа хүргэе.

Танд энэ өдрийн мэнд хүргэе. Таны хүүгээ цэрэгт мордуулж байгаа бичлэг иргэдийн дунд трэнд болж байна лээ...

-Баярлалаа. Хүүгээ цэрэгт мордуулдаг өдөр ямар телевиз нь бичлэг хийснийг нь мэдээгүй. Хүүгээ гээд анхаарах ч сөхөө байсангүй. Тэгсэн орой нь "Эрдэнэт Инфо" сайтынхан бичлэг хийснээ цацаж, түүнийг нь "Монгол цэрэг-Дэлхийн цэрэг" пэйж хуудсаар дамжуулан түгээсэн нь олон хүнд хүрсэн байна лээ. Ах дүү, хамаатан садан, найз нөхөд, ажлын газрынхан "Тунгаа эгч од болжээ" гээд л байна. Юуны өмнө цэрэгт мордсон хүүгээ танилцуулах нь зөв байх. Миний хүүг Болдын Баатарцогт гэдэг. Орхон аймагтаа Ерөнхий боловсролын сургуулиа дүүргэж, МСҮТ-д трактор механик машинист мэргэжлээр суралцаж төгссөн, 19 настай. Багаасаа таеквондоогоор хичээллэж, үзүүлсэн амжилт нь ч их. Гэрээр дүүрэн медальтай. Бас сайхан дуулна. Сурагч байхдаа спорт, урлаг гээд хослуулж хичээллэсэн, хүсэл тэмүүлэл өндөр, аав, ээжийнхээ үгэнд сайн ордог, төлөв томоотой. Хань бид дөрвөн хүүхэдтэй. Миний хань А.Болд "Эрдэнэт" ТӨҮГ-ын Дулааны цахилгаан станцын зуухны хэсгийн зуухны машинистаар ажилладаг. Би 24, манай хүн 22 дахь жилдээ "Эрдэнэт" ТӨҮГ-таа ажиллаж байна. Аав нь одоогоор ээлжийн амралттай, БНСУ-д түр хугацаагаар очсон байгаа учраас хүүг нь харуулчих санаатай гар утсаа бариад гүйгээд байсан нь бичлэгт орсон байна лээ. Хамгийн сүүлд "Болдоо, хүү чинь явлаа" гэж орилж байгаа нь хүртэл сайн чагнавал байсан.

Хүүгээ цэрэгт мордуулах мэдрэмжээ хуваалцахгүй юу?

-Үнэхээр сайхан. Цаанаасаа нэг омогшоод, хүүгээрээ бахархаад л. Манай гэрт эх орондоо хэрэгтэй эр хүн байгаа гэж бодохоор өөрийн эрхгүй онгирах мэдрэмж төрөөд байдаг юм билээ. Энэ мэдрэмжийг ээж бүхэн мэдрээсэй гэж хүсэх байна. Хэдий

хэсэг хугацаанд үр минь гэртээ байхгүй гэж бодохоор гунигтай, сэтгэл хоосон оргих мэт байх ч цаана нь үлдэх дурсамж хамгийн сайхан. Би хүүтэйгээ цэрэгт явах тухай байнга ярилцаж, үүрэг хариуцлагыг нь бага багаар ойлгуулсан ээж гэж хэлж болно. Цэрэгт явахынхаа өмнөхөн БНСУ-д очихоод "Ээж, одоо зарлан ирэх болж байгаа байх" гээд хүрээд ирсэн хүн шүү дээ. Дурлаж, дурлаж явсан. Аав бид хоёр үүнд нь баяртай байгаа. Миний хүү "Торгон цэрэг болох сон" гэж ярьдаг байсан ч Орхон аймагт тэр хуваарь нь байгаагүй болохоор Хилийн цэргийн ангид хуваарилагдсан. Өчигдөр цуг яваа хүнийхээ утсаар ярина лээ. "Ээж ээ, хүү нь Дорнод аймгийн Халх гол суманд байдаг анги руу явж байна. Санаа зоволтгүй шүү" гэсэн. Би нэг зүйлд их баяртай байгаа.

Тэр нь юу вэ?

-Миний хүү "Ээжээ, та бид хоёр бичлэгт гоё гарч байна лээ" гэж баярлаад л. Ээжийгээ олон хүнд ийм сайхан үлгэр жишээ байдлаар таниулсандаа баярлаж, түүндээ урамшиж, урам зориг дүүрэн яваад нь. Нуулгүй хэлэхэд, хань бид хоёр амьдралын хатуу нугачааг хамтдаа туулж яваа хоёр. Сайхан амьдралтай золгож, аз жаргалтай явсан 22-хон настай том охиноо нэг гаруй жилийн өмнөхөн зуурдаар алдсан нь хүнд цочролд оруулсан. Одоо охиныхоо үрийг охиноо гэж бодон өсгөж байна. Н.Хонгорзул гээд зургаан настай цэцэг шиг охин бидэнд бий. Миний бурхан болооч охин таеквондоогоор хичээллэдэг, улсын аварга хүртэл болж байлаа. Хүү маань албандаа "Нэг жилийн дараа хүүгээ ямар эр хүн болсныг хараарай. Магад цэргийн хүн болоод үлдэж ч магад шүү" гээд л явсан, эр хүн бүрийн хаах ёстой албыг үлгэр жишээ хаана гэдэгт нь аав, ээж нь итгэлтэй байна. Цовоо сэргэлэн, ахмад настны үгийг сайн сонсдог, бусадтай нийцтэй, спортлог, авьяаслаг болохоор жавхаатай сайхан цэрэг болох байх аа. Эх хүн бүрийн мэдрэх ёстой дахин давтагдашгүй бөгөөд онцгой мэдрэмж бол хүүгээ цэрэгт мордуулах мөч юм байна гэдгийг өөрийн биеэр ойлгосондоо баяртай байгаа.

Ахмад Д.БОЛОР

ШУА-ИЙН ХИМИ, БИОЛОГИЙН САЛБАРЫН БАГА ЧУУЛГАНД ГИШҮҮНТЭЙ БОЛЛОО



Шинжлэх Ухааны Академийн Хими, биологийн салбарын бага чуулганы нөхөн сонгууль явагдаж дүнгээ гаргалаа.

Сонгуулиар Батлан Хамгаалахын Эрдэм Шинжилгээний Хүрээлэнгийн Дайн, цэргийн урлаг судлалын төвийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд


профессор С.Пүрэвдорж 88,8 хувийн санал авч Батлан хамгаалах салбар анх удаа ШУА-ийн Хими, биологийн салбарын бага чуулганд гишүүнтэй боллоо.

Тэрээр, 1985 онд ЗХУ-ын Хими-хамгаалалтын цэргийн дээд сургуулийг цэргийн химийн командын мэргэжлээр, 1997 онд БХИС-ийн Батлан хамгаалахын удирдлагын академийг команд-штаб, оператив тактикийн мэргэжлээр, 2012 онд ХБНГУ-ын Жорж Маршаллын нэрэмжит Европын аюулгүй байдлын судалгааны төвийн үндсэн дамжааг тус тус төгссөн. Цэргийн химич, команд-штаб, оператив-тактикийн мэргэжилтэй, "Олон улсын терроризмоос сэргийлэх, болзошгүй хөнөөлийн хохирлыг арилгах арга зам" сэдвээр цэргийн ухааны докторын зэргийг 2014 онд хамгаалсан бол одоо Олон улсын терроризм, түүнээс үүсэх эрсдэлийн онол, арга зүйн судалгаа" сэдвээр шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалахаар судалгааны ажлаа гүйцэтгэж байгаа юм.

БХЭШХ



ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ УРЬЖ БАЙНА



"ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ"

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 45 жилийн ойн арга хэмжээг угтаж зохион байгуулж буй цуврал арга хэмжээний нэг болгож тус хүрээлэнгийн Энхийг дэмжих олон улсын судалгааны төвөөс "Энхийг дэмжих ажиллагаанд тулгамдаж байгаа асуудал, шийдвэрлэх арга зам" сэдэвт хэлэлцүүлгийг 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 10:00-14:00 цагт ҮБХИС-ийн Төв номын сангийн 4 дүгээр давхрын хурлын зааланд зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлыг хангаж байна.

Хэлэлцүүлгийг Энхийг дэмжих ажиллагааны цаашдын чиг хандлага, тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлох, түүнийг шийдвэрлэх

арга замын талаар мэдээлэл, туршлага солилцож, хэлэлцүүлэг өрнүүлж энэ чиглэлд судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлэх боломжийг тодорхойлох юм.

Хэлэлцүүлгийн үеэр НҮБ-ийн суурин зохицуулагчийн газрын Хүний эрхийн үндэсний зөвлөх, ноён Ч.Алтангэрэл "НҮБ-ийн энхийг сахиулах ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, сайн туршлага", Агаарын цэргийн командлалын штабын дарга, бригадын генерал Б.Эрдэнэбат "Энхийг дэмжих ажиллагааны бодлого, цаашдын чиг хандлага" сэдвээр тус тус илтгэл, мэдээлэл хийнэ.

БХЭШХ

ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ УРЬЖ БАЙНА

2023.05.10

БХЭШХ-ийн Батлан хамгаалахын дүн шинжилгээний төв БХЯ, ЗХЖШ, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын төлөөлөлтэй хамтран 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 14:00-16:30 цагт "Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаанд

тулгамдаж буй асуудал" сэдэвт эрдэм шинжилгээний хэлэлцүүлгийг ҮБХИС-ийн "Их Эе" танхимд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Уг хэлэлцүүлгээр төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагааны эрх зүйн орчин, залуу

боловсон хүчинд тулгамдаж буй нийгмийн болон албаны асуудлаар мэдээлэл, туршлага солилцож, хэлэлцүүлэг өрнүүлж энэ чиглэлд судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлэх боломжийг тодорхойлох юм.

Референт-эрдэм шинжилгээний ажилтан Э.ТҮВШИН